



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС ХООРОНДЫН ШУУДАН ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН ГАЗРЫН 2021  
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/189/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn  
Аудитор: Ц.Цэрэнхүү  
Утас: 261740 Цахим хаяг: tserenkhuu\_audit@yahoo.com  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Б энд С аудит ХХК  
Захирал: Д.Дашхорлоо  
Утас: 70114810 Цахим хаяг: audit\_bc@yahoo.com

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

---

|  |    |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                  | 1  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                           | 1  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                        | 2  |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....             | 3  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                             | 4  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                         | 5  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                  | 6  |
| 3. Аудитын тайлан.....   | 7  |
| 3.1 Ерөнхий зүйл.....  | 7  |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                       | 7  |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....                             | 8  |
| 3.4 Материаллаг байдал .....   | 8  |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....                                  | 8  |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....                       | 9  |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....                   | 9  |
| 3.8 Аудитын гол асуудал .....  | 9  |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... | 10 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....                           | 10 |
| 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....              | 10 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....                              | 10 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| ТӨБЗГ    | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                   |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/424

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

701050494

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Данс        | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл               | Эцсийн үлдэгдэл              |
|-------------|---|------------------------------|------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b><u>40,617,246.07</u></b>  | <b><u>33,957,196.94</u></b>  |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | -                            | -                            |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | -                            | 46,200.00                    |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>   | -                            | 46,200.00                    |
| 3351        | Байгууллагаас авах авлага   | -                            | 46,200.00                    |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 40,617,246.07                | 33,910,996.94                |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>   | 374,000.00                   | -                            |
| 35110       | Тусгай зориулалттай материал  | 374,000.00                   | -                            |
| 35300       | Бэлэн бүтээгдэхүүн  | 197,500.00                   | -                            |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | 40,045,746.07                | 33,910,996.94                |
| 35410       | Бичиг хэргийн материал  | 6,209,550.00                 | 6,308,666.67                 |
| 35420       | Аж ахуйн материал   | 19,882,797.03                | 16,295,315.78                |
| 35440       | Түлш, шатах тослох материал   | 1,605,000.00                 | 1,221,265.49                 |
| 35470       | Бусад хангамжийн материал   | 12,348,399.04                | 10,085,749.00                |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>684,658,952.01</u></b> | <b><u>708,736,571.40</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 684,658,952.01               | 708,736,571.40               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | 651,669,181.01               | 675,829,300.40               |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл  | 109,196,000.00               | 299,745,000.00               |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл   | 67,571,000.00                | 151,475,000.00               |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 885,936,919.00               | 893,511,314.00               |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | 283,472,927.81               | 372,178,969.52               |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 35,292,854.81                | 36,064,454.81                |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | 27,712,664.99                | 29,837,498.89                |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | 32,989,771.00                | 32,907,271.00                |
| 39301       | Программ хангамж  | 33,536,021.00                | 33,536,021.00                |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | 546,250.00                   | 628,750.00                   |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>725,276,198.08</u></b> | <b><u>742,693,768.34</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | -                            | -                            |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | -                            | -                            |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | -                            | -                            |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг   | -                            | -                            |
| 41320       | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      | -                            | -                            |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>  | -                            | -                            |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг  | -                            | -                            |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг  | -                            | -                            |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>725,276,198.08</u></b> | <b><u>742,693,768.34</u></b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 725,276,198.08               | 742,693,768.34               |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 264,349,638.94               | 264,349,638.94               |
| 51101       | Өмч: - төрийн   | 264,349,638.94               | 264,349,638.94               |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 460,926,161.14               | 443,409,331.40               |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | 114,033,297.11               | 460,926,161.14               |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | 346,892,864.03               | (17,516,829.74)              |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 398.00                       | 34,934,798.00                |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>725,276,198.08</u></b> | <b><u>742,693,768.34</u></b> |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан / төгрөгөөр/

| Код         | Үзүүлэлт  | Өмнөх он                | Тайлант он              |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>1,941,638,479.66</b> | <b>1,777,789,365.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>302,099,379.66</b>   | <b>17,931,565.00</b>    |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 302,099,379.66          | 17,931,565.00           |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 302,099,379.66          | 17,931,565.00           |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 302,099,379.66          | 17,931,565.00           |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>1,639,539,100.00</b> | <b>1,759,857,800.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 1,542,439,100.00        | 1,652,225,800.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 1,542,439,100.00        | 1,652,225,800.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>97,100,000.00</b>    | <b>104,145,000.00</b>   |
| 131103      | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,100,000.00           | 104,145,000.00          |
| <b>1330</b> | <b>Төсвийн захирагчдаас</b>   | -                       | 3,487,000.00            |
| 133003      | Хөрөнгийн   |                         | 3,487,000.00            |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>1,592,905,150.63</b> | <b>1,795,283,754.74</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>1,592,905,150.63</b> | <b>1,795,283,754.74</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>1,555,823,266.29</b> | <b>1,745,553,587.68</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | <b>1,255,147,568.07</b> | <b>1,346,770,625.26</b> |
| 210101      | Үндсэн цалин  | 737,988,831.42          | 768,562,207.69          |
| 210102      | Нэмэгдэл  | 304,396,951.00          | 327,935,384.43          |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 55,969,060.20           | 89,274,158.25           |
| 210104      | Урамшуулал  | 156,792,725.45          | 160,998,874.89          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | <b>160,441,091.35</b>   | <b>180,339,431.53</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 109,892,228.86          | 127,493,077.09          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 12,876,615.78           | 8,984,400.00            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 12,557,415.67           | 19,201,154.44           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | -                       | 2,246,100.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 25,114,831.04           | 22,414,700.00           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | <b>14,373,166.73</b>    | <b>13,753,271.63</b>    |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,173,166.73            | 838,271.63              |
| 210304      | Байрны түрээс   | 13,200,000.00           | 12,915,000.00           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>16,832,557.54</b>    | <b>25,688,211.40</b>    |
| 210401      | Бичиг хэрэг   | 3,883,320.00            | 6,712,933.33            |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 6,151,983.00            | 8,023,334.51            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 1,067,081.54            | 1,177,681.52            |
| 210405      | Хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал   | -                       | 7,240.00                |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 5,730,173.00            | 5,800,053.00            |
| 210408      | Бараа материал акалсны зардал   |                         | 3,966,969.04            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>24,503,883.00</b>    | <b>29,721,275.00</b>    |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 1,965,799.00            | 1,599,500.00            |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл  | 3,205,600.00            | 24,535,200.00           |
| 210604      | Урсгал засвар   | 19,332,484.00           | 3,586,575.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | <b>14,266,362.00</b>    | <b>15,467,327.25</b>    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 5,759,700.00            | 7,500,000.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 2,000,000.00            | 2,000,000.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 2,300,130.00            | 2,469,780.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | 156,332.00              | 216,350.00              |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 60,000.00               | 104,000.00              |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 112,200.00              | -                       |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх  | 3,878,000.00            | 3,177,197.25            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>70,258,637.60</b>    | <b>133,813,445.61</b>   |



|             |   |                       |                        |
|-------------|---|-----------------------|------------------------|
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                 |                       | 6,390,990.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх               | 200,000.00            | 330,000.00             |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол              | 70,058,637.60         | 127,092,455.61         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                         | <b>37,081,884.34</b>  | <b>49,730,167.06</b>   |
| <b>2135</b> | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт         | <b>37,081,884.34</b>  | <b>49,730,167.06</b>   |
| 213503      | Төвлөрүүлэх шилжүүлэг                           | 37,081,884.34         | 49,730,167.06          |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>       | <b>348,733,329.03</b> | <b>(17,494,389.74)</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>          | <b>1,840,465.00</b>   | <b>22,440.00</b>       |
| 225005      | Үнэ төлбөргүй гарсан зардал                     | 1,840,465.00          | 22,440.00              |
| <b>4</b>    | <b>Үйл ажиллагааны бус үр дүн (4)=(145-225)</b> | <b>(1,840,465.00)</b> | <b>(22,440.00)</b>     |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                  | <b>346,892,864.03</b> | <b>(17,516,829.74)</b> |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1   | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 264,349,638.9                   | 398.0                 | 114,033,297.1     | 378,383,334.1                          |
| 2   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 264,349,638.9                   | 398.0                 | 114,033,297.1     | 378,383,334.1                          |
| 3   | Тайлант үеийн үр дүн                             |                                 |                       | 346,892,864.0     | 346,892,864.0                          |
| 4   | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 264,349,638.9                   | 398.0                 | 460,926,161.1     | 725,276,198.1                          |
| 5   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                       | 264,349,638.9                   | 398.0                 | 460,926,161.1     | 725,276,198.1                          |
| 6   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт |                                 | 34,934,400.0          |                   | 34,934,400.0                           |
| 7   | Тайлант үеийн үр дүн                             |                                 |                       | -17,516,829.7     | -17,516,829.7                          |
| 8   | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл            | 264,349,638.9                   | 34,934,798.0          | 443,409,331.4     | 742,693,768.3                          |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Данс        | Үзүүлэлт  | Өмнөх он                | Тайлант он              |
|-------------|---|-------------------------|-------------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>   |                         |                         |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>   | <b>1,639,539,100.00</b> | <b>1,756,370,800.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>1,639,539,100.00</b> | <b>1,756,370,800.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | <b>1,542,439,100.00</b> | <b>1,652,225,800.00</b> |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 1,542,439,100.00        | 1,652,225,800.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | <b>97,100,000.00</b>    | <b>104,145,000.00</b>   |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,100,000.00           | 104,145,000.00          |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>  | <b>1,530,839,100.00</b> | <b>1,646,510,010.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>1,530,839,100.00</b> | <b>1,646,510,010.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | <b>1,493,757,215.66</b> | <b>1,596,779,842.94</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | <b>1,252,714,700.04</b> | <b>1,346,770,625.26</b> |
| 210101      | Үндсэн цалин  | 743,711,476.80          | 768,562,207.69          |
| 210102      | Нэмэгдэл  | 325,658,831.18          | 327,935,384.43          |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 40,346,592.36           | 89,274,158.25           |
| 210104      | Урамшуулал  | 142,997,799.70          | 160,998,874.89          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | <b>160,441,091.35</b>   | <b>180,385,631.53</b>   |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 118,890,139.60          | 127,493,077.09          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 10,530,810.26           | 8,984,400.00            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 8,272,591.04            | 19,201,154.44           |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 2,066,222.77            | 2,246,100.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 20,681,327.68           | 22,460,900.00           |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | <b>14,373,166.73</b>    | <b>13,753,271.63</b>    |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 1,173,166.73            | 838,271.63              |
| 210304      | Байрны түрээс   | 13,200,000.00           | 12,915,000.00           |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | <b>24,451,611.54</b>    | <b>18,077,113.52</b>    |
| 210401      | Бичиг хэрэг   | 6,329,530.00            | 6,289,650.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 7,255,000.00            | 7,639,600.00            |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 1,067,081.54            | 1,177,681.52            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал   | -                       | 54,040.00               |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 9,800,000.00            | 2,916,142.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>  | <b>28,231,084.00</b>    | <b>21,433,971.00</b>    |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл   | 4,159,500.00            | 2,005,396.00            |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл  | 5,847,500.00            | 15,842,000.00           |
| 210604      | Урсгал засвар   | 18,224,084.00           | 3,586,575.00            |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>   | <b>13,345,562.00</b>    | <b>16,029,230.00</b>    |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр  | 5,759,700.00            | 7,500,000.00            |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох  | 2,000,000.00            | 2,000,000.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 2,300,130.00            | 2,469,780.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар  | 156,332.00              | 216,350.00              |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо   | 60,000.00               | 104,000.00              |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 112,200.00              | 210,000.00              |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх  | 2,957,200.00            | 3,529,100.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>  | <b>200,000.00</b>       | <b>330,000.00</b>       |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 200,000.00              | 330,000.00              |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>37,081,884.34</b>    | <b>49,730,167.06</b>    |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүл</b>  | <b>37,081,884.34</b>    | <b>49,730,167.06</b>    |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 37,081,884.34           | 49,730,167.06           |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>   | <b>108,700,000.00</b>   | <b>109,860,790.00</b>   |
| <b>5</b>    | <b>ХО-ТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>  | <b>108,700,000.00</b>   | <b>109,860,790.00</b>   |



|             |  |                         |                         |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>108,700,000.00</b>   | <b>109,860,790.00</b>   |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | 108,700,000.00          | 109,860,790.00          |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 108,700,000.00          | 109,860,790.00          |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b>(108,700,000.00)</b> | <b>(109,860,790.00)</b> |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | 0.00                    | <b>(0.00)</b>           |
| <b>9</b>    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                           | 0.00                    | 0.00                    |
| <b>10</b>   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                          | 0.00                    | 0.00                    |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт   | Төлөвлөгөө              | Гүйцэтгэл              | Зөрүү               | Хувь        |
|--|-------------------------|------------------------|---------------------|-------------|
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>1,652,225,800.00</b> | <b>1,602,495,632.9</b> | <b>49,730,167.1</b> | <b>97.0</b> |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,652,225,800.00</b> | <b>1,602,495,632.9</b> | <b>49,730,167.1</b> | <b>97.0</b> |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | <b>1,652,225,800.0</b>  | <b>1,602,495,632.9</b> | <b>49,730,167.1</b> | <b>97.0</b> |
| <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | <b>1,363,047,000.0</b>  | <b>1,346,770,625.3</b> | <b>16,276,374.7</b> | <b>98.8</b> |
| Үндсэн цалин   | 784,315,200.0           | 768,562,207.7          | 15,752,992.3        | 98.0        |
| Нэмэгдэл   | 328,076,400.0           | 327,935,384.4          | 141,015.6           | 100.0       |
| Унаа хоолны хөнгөлөлт  | 89,655,400.0            | 89,274,158.3           | 381,241.8           | 99.6        |
| Урамшуулал   | 161,000,000.0           | 160,998,874.9          | 1,125.1             | 100.0       |
| <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>192,096,100.0</b>    | <b>180,385,631.5</b>   | <b>11,710,468.5</b> | <b>93.9</b> |
| Тэтгэврийн даатгал   | 135,943,800.0           | 127,493,077.1          | 8,450,722.9         | 93.8        |
| Тэтгэмжийн даатгал   | 8,984,400.0             | 8,984,400.0            | 0.0                 | 100.0       |
| ҮОМШӨ-ний даатгал  | 22,460,900.0            | 19,201,154.4           | 3,259,745.6         | 85.5        |
| Ажилгүйдлийн даатгал   | 2,246,100.0             | 2,246,100.0            | 0.0                 | 100.0       |
| Эрүүл мэндийн даатгал  | 22,460,900.0            | 22,460,900.0           | 0.0                 | 100.0       |
| <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>15,354,900.0</b>     | <b>13,753,271.6</b>    | <b>1,601,628.4</b>  | <b>89.6</b> |
| Гэрэл, цахилгаан   | 1,354,900.0             | 838,271.6              | 516,628.4           | 61.9        |
| Байрны түрээс  | 14,000,000.0            | 12,915,000.0           | 1,085,000.0         | 92.3        |
| <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>20,138,500.0</b>     | <b>18,357,103.5</b>    | <b>1,781,396.5</b>  | <b>91.2</b> |
| Бичиг хэрэг  | 7,356,100.0             | 6,289,650.0            | 1,066,450.0         | 85.5        |
| Тээвэр, шатахуун   | 7,675,000.0             | 7,639,600.0            | 35,400.0            | 99.5        |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,177,000.0             | 1,177,681.5            | -681.5              | 100.1       |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 330,400.0               | 54,040.0               | 276,360.0           | 16.4        |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 3,600,000.0             | 3,196,132.0            | 403,868.0           | 88.8        |
| <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>41,168,900.0</b>     | <b>26,869,771.0</b>    | <b>14,299,129.0</b> | <b>65.3</b> |
| Багаж, техник, хэрэгсэл  | 10,274,000.0            | 7,441,196.0            | 2,832,804.0         | 72.4        |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 15,894,900.0            | 15,842,000.0           | 52,900.0            | 99.7        |
| Урсгал засвар  | 15,000,000.0            | 3,586,575.0            | 11,413,425.0        | 23.9        |
| <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>19,980,000.0</b>     | <b>16,029,230.0</b>    | <b>3,950,770.0</b>  | <b>80.2</b> |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,900,000.0             | 7,500,000.0            | 2,400,000.0         | 75.8        |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 3,000,000.0             | 2,000,000.0            | 1,000,000.0         | 66.7        |

|   |                        |                        |                     |             |
|---|------------------------|------------------------|---------------------|-------------|
| Даатгалын үйлчилгээ                               | 2,500,000.0            | 2,469,780.0            | 30,220.0            | 98.8        |
| Тээврийн хэрэгслийн татвар                        | 250,000.0              | 216,350.0              | 33,650.0            | 86.5        |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо                     | 180,000.0              | 104,000.0              | 76,000.0            | 57.8        |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ                   | 250,000.0              | 210,000.0              | 40,000.0            | 84.0        |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх            | 3,900,000.0            | 3,529,100.0            | 370,900.0           | 90.5        |
| <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>            | <b>440,400.0</b>       | <b>330,000.0</b>       | <b>110,400.0</b>    | <b>74.9</b> |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                 | 440,400.0              | 330,000.0              | 110,400.0           | 74.9        |
| <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>             | <b>1,652,225,800.0</b> | <b>1,602,495,632.9</b> | <b>49,730,167.1</b> | <b>97.0</b> |
| <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                    | <b>1,652,225,800.0</b> | <b>1,602,495,632.9</b> | <b>49,730,167.1</b> | <b>97.0</b> |
| Улсын төсвөөс санхүүжих                           | 1,652,225,800.0        | 1,602,495,632.9        | 49,730,167.1        | 97.0        |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0                      | 0                      | 0.00                |             |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0                      | 0                      | 0.00                |             |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

| Данс        | Үзүүлэлт                                 | Төлөвлөгөө | Гүйцэтгэл             |
|-------------|--|------------|-----------------------|
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b> |            | <b>104,145,000.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                     |            | <b>104,145,000.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   |            | <b>104,145,000.00</b> |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b> |            | <b>18,000,000.00</b>  |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                  |            | 18,000,000.00         |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   |            | <b>86,145,000.00</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал          |            | 86,145,000.00         |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>    |            | <b>104,145,000.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>      |            | <b>104,145,000.00</b> |
| 131104      | нэмэлт санхүүжилтийн орлого              |            | 104,145,000.00        |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 21-ний хооронд Б энд С аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Заяажаргал, аудитор С.Алтанцэцэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Ц.Жамъянхорол хэрэгжүүлсэн.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Б энд С аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газар нь улсын хилээр нэвтэрч буй шуудан илгээмжид гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалт хийх /код 9412/ үндсэн үйл ажиллагаа явуулахдаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, үйлчлүүлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх зарчмыг баримтлан, барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай Олон улсын конвенци болон холбогдох бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Гаалийн байгууллагын стратеги, зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах;
- Бараа тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх ;
- Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх;
- Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,594,745.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 15,947.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улс хоорондын шуудан илгээмжийн Гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,417.6 мянган төгрөгөөр буюу 102.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансдуудын үлдэгдэлд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл  | Өөрчлөлт        |
|---|------------------|------------------|-----------------|
| Б   | 1                | 2                | 3=2-1           |
| Авлага  | -                | 46.2             | 46.2            |
| Бараа материал                                    | 40,617.2         | 33,911.0         | (6,706.2)       |
| Үндсэн хөрөнгө                                    | 684,658.9        | 708,736.6        | 24,077.6        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>725,276.2</b> | <b>742,693.8</b> | <b>17,417.6</b> |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 725,276.2        | 742,693.8        | 17,417.6        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>725,276.2</b> | <b>742,693.8</b> | <b>17,417.6</b> |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй, Төсвийн жил дуусахад хэмнэгдсэн санхүүжилтийг улсын төсөв рүү төвлөрүүлэн шилжүүлсэн;
- Авлага дансны үлдэгдэлд 46.2 мянган төгрөг байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлснээс үүссэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл 33,911.0 мянган төгрөг болж 6,706.2 мянган төгрөгөөр буурсан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,262,856.8 мянган төгрөг болж 198,895.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 252,674.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч, 53,779.1 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассанаас шалтгаалжээ. Урсгал төсвийн хөрөнгөөр 109,860.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 98,600.0 мянган төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл болон бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 44,213.3 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,370,025.8 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 282,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,652,225.8 мянган төгрөгөөр баталсан байна. Гаалийн ерөнхий газрын даргын шинэчлэн баталсан хөдөлмөрийн дотоод журамд заагдсаны дагуу албан хаагчдын хоолны мөнгө нэмэгдэж цалингийн зардал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,652,225.8 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 1,602,495.6 мянган төгрөгийг зарцуулж 49,730.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дагуу Засгийн газрын нөөц сангаас 104,145.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч уг санхүүжилтийн хүрээнд Гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагааг шуурхай зохион байгуулахад шаардлагатай бага оврын автобус 86,145.0 мянган төгрөгөөр, мөн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сурталчлах ажлын хүрээнд 4 ширхэг дэлгэцийг 18,000.0 мянган төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон онцолсон асуудал байхгүй учир санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгад тусгагдаагүй асуудал байхгүй болно.

Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт, дүгнэлт гаргахын тулд АОУС 706.10-д зааснаар аудитор аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжтой байх ёстой. Аудитын хамрах хүрээнд хязгаарлалт үүсээгүй учир аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломж бүрдсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар нь 2021 онд нийт 1,756,370.8 мянган төгрөгийн 149 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2021 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын аудитаар 98,616.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

- Цалинтай чөлөө авсан 2 албан хаагчдад 616.1 мянган төгрөгийн зэрэг дэв, удаан жил, онцгой нөхцөлийн нэмэгдэл илүү олгосныг 2021 оны 12 дугаар сарын сүүл цалингаас суутган авсан;
- Гаалийн ерөнхий газраас шилжиж ирсэн, байгууллагын өдөр тутмын үйлчилгээнд ашиглаж байгаа 98,000.0 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн Мерседес бенз Е-300 маркын автомашиныг дахин үнэлгээ хийлгэж хөрөнгийг бүртгэлд тусган, тайлант хугацааны элэгдлийг тооцож бүртгэсэн байна.

Өмнөх аудитаар 399,539.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 7,811.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 98.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |                  | Биелэлт  |                  | Зөрүү    |     | Хувь        |
|-----------------|---------------------|------------------|----------|------------------|----------|-----|-------------|
|                 | Тоо                 | Дүн              | Тоо      | Дүн              | Тоо      | Дүн |             |
| Албан шаардлага | 1                   | 399,539.6        | 1        | 399,539.6        |          |     | 100.0       |
| Зөвлөмж         | 5                   | 7,811.0          | 4        | 7,811.0          | 1        |     | 98.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>6</b>            | <b>407,350.6</b> | <b>6</b> | <b>407,350.6</b> | <b>1</b> |     | <b>98.0</b> |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/323 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоог 49-өөр баталсан боловч батлагдсан орон тооноос 28 албан хаагч илүү ажиллуулж 234,714.2 мянган төгрөгийн зардал гаргасан, шаардлагатай орон тоог дээд шатны байгууллагад уламжилж шийдвэрлүүлээгүй байгааг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary.

